



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 77 дугаар зүйлийн 77.11 дэх хэсэг, 95 дугаар зүйлийн 95.7 дэх хэсгийг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ыг Нэгдүгээр, “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварыг Хоёрдугаар, “Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварыг Гуравдугаар, “Ажлын хэсгийн гишүүний баталгаа”-ны загварыг Дөрөвдүгээр, “Ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл”-ийн маягтыг Тавдугаар, “Ашиг сонирхлын зөрчлийн тайлбар”-ын маягтыг Зургаадугаар, “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн талаарх илтгэгч гишүүний дэлгэрэнгүй тайлан”-гийн загварыг Долоодугаар, “Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн талаарх илтгэгч гишүүний дэлгэрэнгүй тайлан”-гийн загварыг Наймдугаар, “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд санал болгосон нэр дэвшигчийн талаарх ажлын хэсгийн тайлан”-гийн загварыг Есдүгээр, “Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд санал болгосон нэр дэвшигчийн талаарх ажлын хэсгийн тайлан”-гийн загварыг Аравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолыг 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ



Л.СОРОНЗОНБОЛД

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн
байнгын хорооны 2026 оны 04 дугаар
сарын 29 -ны өдрийн 04 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН БОЛОН ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ШҮҮГЧ БУС ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилт Монгол Улсын Шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ /цаашид “Шүүхийн тухай хууль” гэх/-ийн 77.11 дэх хэсэг, 95.7 дахь хэсэгт заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Шүүхийн ерөнхий зөвлөл /цаашид “Ерөнхий зөвлөл” гэх/-ийн, эсхүл Шүүхийн сахилгын хороо /цаашид “Сахилгын хороо” гэх/-ны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулалтыг сул орон тоо гарсан тоогоор зарлаж, Шүүхийн тухай хууль, энэ журамд заасны дагуу сонгон шалгаруулна.

1.3.Ерөнхий зөвлөлийн, эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулахад дараах зарчмыг баримтална:

- 1.3.1.хууль дээдлэх;
- 1.3.2.шударга байх;
- 1.3.3.хараат бус байх;
- 1.3.4.бодитой хандах;
- 1.3.5.нээлттэй, ил тод байх;
- 1.3.6.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.

1.4.Энэ журамд хэрэглэсэн дараах нэршлийг доор дурдсан утгаар ойлгоно:

1.4.1.“сонгон шалгаруулалт” гэж Ерөнхий зөвлөлийн, эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг;

1.4.2.“хүсэлт гаргагч” гэж Ерөнхий зөвлөлийн, эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүний сул орон тоонд нэр дэвших тухай хүсэлт гаргасан иргэнийг;

1.4.3.“Ажлын хэсэг” гэж Шүүхийн тухай хуулийн 77.1.6 дахь хэсэг болон энэ журамд заасны дагуу Байнгын хорооны тогтоолоор байгуулсан ажлын хэсгийг;

1.4.4.“нэр дэвшигч” гэж энэ журмын 8.2.2-т заасны дагуу сонгон шалгаруулалтад нэр дэвшигчээр бүртгэсэн иргэнийг.

Хоёр.Ерөнхий зөвлөлийн, эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигчид тавих шаардлага

2.1.Ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь Шүүхийн тухай хуулийн 76.1 дэх хэсэгт заасан хязгаарлалт, 77.10 дахь хэсэгт заасан хориглолтод хамаарахгүй Монгол Улсын иргэн байх бөгөөд Шүүхийн тухай хуулийн 76.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

2.2.Сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь Шүүхийн тухай хуулийн 95.9 дэх хэсэгт заасан хязгаарлалт, 77.10 дахь хэсэг, 95.4, 95.8 дахь хэсэгт заасан хориглолтод хамаарахгүй Монгол Улсын иргэн байх бөгөөд Шүүхийн тухай хуулийн 95.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

Гурав.Сонгон шалгаруулалтын үе шат

3.1.Сонгон шалгаруулалт нь Шүүхийн тухай хуульд заасан дараалал, ажиллагааны дагуу явагдах бөгөөд дараах үе шатаар зохион байгуулна:

- 3.1.1.сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлэх;
- 3.1.2.нэр дэвших тухай хүсэлтийг хүлээн авах;
- 3.1.3.Ажлын хэсэг байгуулах;
- 3.1.4.нэр дэвшигчээр бүртгэх;
- 3.1.5.нэр дэвшигчийг нийтэд мэдээлж, асуулт, санал хүлээн авах;
- 3.1.6.нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, бүрдүүлэх;
- 3.1.7.Ажлын хэсгийн хэлэлцүүлэг зохион байгуулах;
- 3.1.8.нэр дэвшигчийг тодруулах;
- 3.1.9.нэр дэвшигчийг санал болгох.

3.2.Байнгын хороо энэ журмын 3.1.1, 3.1.2, 3.1.3, 3.1.5-д заасан үйл ажиллагааг зохион байгуулна.

3.3.Ажлын хэсэг энэ журмын 3.1.4, 3.1.6, 3.1.7, 3.1.8, 3.1.9-д заасан үйл ажиллагааг зохион байгуулна.

Дөрөв.Сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлэх

4.1.Шүүхийн тухай хуулийн 77.1.2 дахь заалтад заасан Ерөнхий зөвлөлийн, эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай зар нь ойлгомжтой, тодорхой, хоёрдмол утгагүй бичвэр хэлбэртэй байх бөгөөд дараах мэдээллийг агуулсан байна:

4.1.1.сонгон шалгаруулалтын зорилго;
4.1.2.нэр дэвших тухай хүсэлт гаргах хугацаа;
4.1.3.нэр дэвших тухай хүсэлтийг биечлэн хүлээн авах хаяг, цахим шуудангийн хаяг;

4.1.4.лавлах утасны дугаар;
4.1.5.энэ журмын 2.1, эсхүл 2.2-т заасан Ерөнхий зөвлөлийн, эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүнд тавих шаардлага;

4.1.6.энэ журмын 5.1.1, эсхүл 5.1.2-т заасны дагуу бүрдүүлэх баримт бичиг.

4.2.Энэ журмын 4.1-д заасан зарыг Монгол Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудас /www.parliament.mn/-т байршуулсан өдрийг зарыг нийтэд мэдээлсэн өдөрт тооцно.

4.3.Энэ журмын 4.1-д заасан зарыг Шүүхийн тухай хуулийн 77.1.2 дахь заалтад заасан хугацаанд дараах байдлаар нийтэд мэдээлнэ:

4.3.1.Монгол Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудас /www.parliament.mn/ болон нийгмийн сүлжээний хуудас /ParliamentMN/-т байршуулах;

4.3.2.Монголын үндэсний олон нийтийн радио, телевизээр дамжуулах;

4.3.3.хоёроос доошгүй өдөр тутмын сонинд нийтлүүлэх.

4.4.Энэ журмын 4.2-т заасны дагуу зарыг нийтэд мэдээлснээс хойш нэгээс доошгүй удаа энэ журмын 4.1-д заасан зарын цахим холбоосыг товч тайлбартайгаар дахин нийтэд мэдээлнэ.

4.5.Шаардлагатай тохиолдолд энэ журмын 4.1-д заасан зарыг энэ журмын 4.2-т зааснаас гадна бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлж болно.

Тав.Нэр дэвших тухай хүсэлтийг хүлээн авах

5.1.Иргэн нь энэ журмын 4.2-т заасны дагуу зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 21 хоногийн дотор Ерөнхий зөвлөлийн, эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвших хүсэлтээ Шүүхийн тухай хуулийн дараах хэсэг, заалт, дэд заалтад заасан баримт бичгийг цаасан болон цахим хэлбэрээр Байнгын хороонд хүргүүлнэ:

5.1.1.Ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших хүсэлт гаргасан иргэн Шүүхийн тухай хуулийн 77.1.3 дахь заалтад заасан баримт бичгийг;

5.1.2.Сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвших хүсэлт гаргасан иргэн Шүүхийн тухай хуулийн 77.1.3.а, 77.1.3.б, 77.1.3.в, 77.1.3.г дэх дэд заалт, 95.3 дахь хэсэгт заасан баримт бичгийг болон Шүүхийн тухай хуулийн 95.4, 95.8 дахь хэсэгт заасан хориглолтод хамаарахгүй гэдгийг нотлох баримт бичгийг.

5.2.Энэ журмын 5.1.1-д заасан нэр дэвших тухай хүсэлт гаргасан иргэн энэ журмын хоёрдугаар хавсралтаар, 5.1.2-т заасан нэр дэвших тухай хүсэлт гаргасан иргэн энэ журмын гуравдугаар хавсралтаар баталсан загварын дагуу холбогдох бүх мэдээллийг үнэн зөв, бүрэн бичиж, нотлох баримт бичгийг тус тус бүрдүүлэн хавсаргана.

5.3.Байнгын хорооны ажлын алба хүсэлт гаргагчаас ирүүлсэн нэр дэвших тухай хүсэлт, баримт бичгийг хүлээн авсан огноо, цагийг тэмдэглэн ирүүлсэн дарааллын дагуу бүртгэлийн дугаар олгоно.

5.4.Хүсэлт гаргагчийн нэр дэвших тухай хүсэлт, баримт бичгийг хүлээн авах хугацааг хуанлийн өдрөөр тоолох бөгөөд хугацааны эцсийн өдөр нь амралтын өдөр байвал түүний дараагийн ажлын өдөр хугацаа дууссанд тооцно.

5.5.Хүсэлт гаргагч хугацаа дуусахаас хоёроос доошгүй хоногийн өмнө нэр дэвших тухай хүсэлт, баримт бичгийг ирүүлсэн бол Байнгын хорооны ажлын алба нэр дэвших тухай хүсэлт, баримт бичгийн бүрдүүлбэрийг шалгаж, хангалтгүй, эсхүл ойлгомжгүй байвал энэ талаар хүсэлт гаргагчид мэдэгдэх бөгөөд хүсэлт гаргагч хугацаа дуусахаас өмнө бүрдэл, шаардлагыг хангуулан ирүүлж болно.

5.6.Хугацаа дууссанаас хойш ирүүлсэн хүсэлт гаргагчийн нэр дэвших тухай

хүсэлт, баримт бичгийг хүлээн авахгүй.

5.7.Байнгын хорооны ажлын алба шаардлагатай тохиолдолд хүсэлт гаргагчаас ирүүлсэн нэр дэвших тухай хүсэлт, баримт бичгийн үнэн зөв байдлыг тодруулах зорилгоор холбогдох байгууллагаас лавлагаа, мэдээлэл авч болно.

Зургаа.Ажлын хэсэг байгуулах

6.1.Байнгын хороо энэ журмын 4.2-т заасны дагуу зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш Шүүхийн тухай хуулийн 77.1.6 дахь заалтад заасан хугацаанд Ерөнхий зөвлөлийн, эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүний сонгон шалгаруулалтыг хараат бусаар зохион байгуулах чиг үүрэгтэй Ажлын хэсгийг байгуулна.

6.2.Ажлын хэсэг нь Шүүхийн тухай хуулийн 77.2 дахь хэсэгт заасан этгээд /цаашид “эрх бүхий этгээд” гэх/-ийн санал болгосон 11 гишүүнээс бүрдсэн байх бөгөөд эрх бүхий этгээдийн төлөөллийг дараах байдлаар Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулна:

6.2.1.Монгол Улсын Их Хурлын даргын томилсон Улсын Их Хурлын нэг гишүүн;

6.2.2.Монгол Улсын Их Хурал дахь олонхын бүлгээс санал болгосон нэг төлөөлөл;

6.2.3.Монгол Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгээс санал болгосон нэг төлөөлөл;

6.2.4.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санал болгосон нэг төлөөлөл;

6.2.5.Монгол Улсын Засгийн газраас санал болгосон нэг төлөөлөл;

6.2.6.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын хуралдаанаас санал болгосон нэг төлөөлөл;

6.2.7.Монголын Хуульчдын холбооны Зөвлөлөөс санал болгосон нэг төлөөлөл;

6.2.8.Монголын Өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөлөөс санал болгосон нэг төлөөлөл;

6.2.9.хууль зүйн сургалт, судалгааны байгууллагаас санал болгосон нэг төлөөлөл;

6.2.10.төрийн өмчийн хууль зүйн сургуулийн санал болгосон нэг төлөөлөл;

6.2.11.төрийн бус өмчийн хууль зүйн сургуулийн санал болгосон нэг төлөөлөл.

6.3.Энэ журмын 6.2.3-т заасан Монгол Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгээс санал болгох нэг төлөөллийг дараах журмаар шийдвэрлэнэ:

6.3.1.цөөнхийн бүлэг нэг байвал тухайн цөөнхийн бүлгээс санал авна;

6.3.2.хэрэв цөөнхийн бүлгийн тоо хоёр ба түүнээс дээш тоотой байвал

хамгийн олон гишүүнтэй цөөнхийн бүлгээс санал авна;

6.3.3.хэрэв цөөнхийн бүлгүүдийн гишүүдийн тоо тэнцүү бол цөөнхийн бүлгийн дарга нар тохирлын журмаар санамсаргүй сонголтын аргыг ашиглан шийдвэрлэх бөгөөд уг журмаар сонгогдсон цөөнхийн бүлгээс санал авна;

6.3.4.хэрэв цөөнхийн бүлэг байгуулах гишүүний тоо хүрэлцэхгүй бол цөөнхийн гишүүд хуралдаж олонхын саналаар шийдвэрлэх бөгөөд уг саналыг цөөнхийн бүлгийн санал гэж үзнэ.

6.4.Байнгын хороо энэ журмын 4.2-т заасны дагуу зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш ажлын хоёр өдрийн дотор эрх бүхий этгээдэд өөрийн төлөөллийг Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулах санал авах тухай албан бичгийг дараах тоог баримтлан хүргүүлнэ:

6.4.1.энэ журмын 6.2.1, 6.2.2, 6.2.3, 6.2.4, 6.2.5, 6.2.6, 6.2.7, 6.2.8-д заасан эрх бүхий этгээд тус бүрд нэг;

6.4.2.энэ журмын 6.2.9, 6.2.10, 6.2.11-д заасан эрх бүхий этгээд тус бүрд хоёроос доошгүй.

6.5.Албан бичигт Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахаар санал болгох хүний тоо, тухайн хүнийг тодорхойлох мэдээллийн жагсаалт, санал ирүүлэх огноог тусгах бөгөөд санал ирүүлэх хугацаа нь ажлын таван өдрөөс ихгүй байна.

6.6.Эрх бүхий этгээд албан бичигт заасан хугацаанд Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулах хүний нэр, холбогдох мэдээллийг Байнгын хороонд албан бичгээр ирүүлнэ.

6.7.Байнгын хороо энэ журмын 6.6-д заасны дагуу эрх бүхий этгээд тус бүрээс нэг хүний нэрийг ирүүлсэн бол ирүүлсэн дарааллын дагуу нэг бүрчлэн хэлэлцэж, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар Ажлын хэсгийн гишүүнээр томилж, тогтоол гаргана.

6.8.Энэ журмын 6.2.9, 6.2.10, 6.2.11-д заасан эрх бүхий этгээд тус бүрээс хоёроос доошгүй хүний нэрийг ирүүлсэн бол Байнгын хороо ирүүлсэн дарааллын дагуу хүн тус бүрээр хэлэлцэж, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналыг авсан дарааллаар эрэмбэлж, хамгийн олон санал авсан хүнийг Ажлын хэсгийн гишүүнээр томилж, тогтоол гаргана.

6.9.Энэ журмын 6.8-д заасны дагуу Ажлын хэсгийн гишүүнийг томилоход Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн саналын тоо тэнцсэн бол дахин санал хураалт явуулах бөгөөд эрх бүхий этгээдээс нэрийг нь ирүүлсэн дарааллын дагуу санал хураалт явуулж, хамгийн эхэнд Байнгын хорооны хуралдаанд гишүүдийн олонхын санал авсан хүнийг Ажлын хэсгийн гишүүнээр томилно.

6.10.Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх эрх бүхий этгээдээс нэрийг нь ирүүлсэн хүнийг Ажлын хэсгийн гишүүнээр томилохыг дэмжээгүйн улмаас энэ журмын 6.2-т заасан эрх бүхий байгууллагын төлөөлөл Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж чадаагүй бол Байнгын хороо ажлын нэг өдрийн дотор өөр хүний нэрийг холбогдох мэдээллийн хамт ирүүлэх тухай албан тоотыг эрх бүхий этгээдэд хүргүүлэх бөгөөд тухайн эрх бүхий этгээд уг албан тоотын хариуг

ажлын хоёр өдрийн дотор Байнгын хороонд ирүүлнэ.

6.11.Ажлын хэсгийг Шүүхийн тухай хуулийн 77.2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын даргын захирамжаар томилсон Улсын Их Хурлын гишүүн ахлах бөгөөд Байнгын хороо энэ талаар шийдвэр гаргахгүй.

6.12.Шүүхийн тухай хуульд заасны дагуу Ерөнхий зөвлөлийн болон Сахилгын хорооны шүүгч бус гишүүний сонгон шалгаруулалтыг зохион байгуулах хугацаа давхацсан нь сонгон шалгаруулалтыг нэг Ажлын хэсэгт хариуцуулах үндэслэл болохгүй бөгөөд сонгон шалгаруулалтыг тус тусад нь зохион байгуулах хоёр Ажлын хэсгийг энэ журамд заасны дагуу байгуулна.

6.13.Энэ журмын 6.12-т заасан хоёр Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэг хүнийг давхар оруулахыг хориглоно.

6.14.Энэ журмын 8.6-д заасан үндэслэлээр сонгон шалгаруулалтын зарыг дахин явуулах бол Ажлын хэсгийг шинээр байгуулахгүй.

6.15.Энэ журмын 12.8-д заасан үндэслэлээр сонгон шалгаруулалтын зарыг дахин явуулах бол Ажлын хэсгийг үргэлжүүлэн ажиллуулах, эсхүл шинээр байгуулах эсэхийг Байнгын хороо шийдвэрлэнэ.

6.16.Энэ журмын 7.7-д заасны дагуу Ажлын хэсгийн гишүүн сонгон шалгаруулах үйл ажиллагаанаас татгалзан гарч, ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдлийг бөглөж Байнгын хороонд ирүүлсэн, эсхүл 7.9.2-д заасны дагуу Ажлын хэсгийн гишүүнийг чөлөөлсөн бол Байнгын хороо санал болгосон эрх бүхий этгээдэд өөр хүний нэрийг холбогдох мэдээллийн хамт ирүүлэх тухай албан тоотыг эрх бүхий этгээдэд хүргүүлэх бөгөөд тухайн эрх бүхий этгээд уг хүсэлтийн хариуг ажлын нэг өдрийн дотор Байнгын хороонд ирүүлнэ.

6.17.Байнгын хороо энэ журмын 6.10, эсхүл 6.16-д заасан нөхцөл бий болж, эрх бүхий этгээдээс хариу ирсэн бол энэ журамд заасны дагуу Ажлын хэсгийн гишүүнийг томилно.

6.18.Ажлын хэсгийн ажиллах нөхцөлийг Байнгын хороо хангах бөгөөд Байнгын хорооны ажлын алба техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ.

6.19.Энэ журамд заасны дагуу холбогдох баримт бичиг, зар, бусад мэдээллийг цахим хуудаст байршуулах, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр түгээх, нийтэд мэдээлэх, мэдээллийн технологийг ашиглахад Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан нэгж болон мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж техник, зохион байгуулалт, арга зүйн туслалцаа үзүүлнэ.

Долоо.Ажлын хэсгийн үйл ажиллагаа

7.1.Ажлын хэсэг үйл ажиллагаагаа Шүүхийн тухай хууль болон энэ журамд нийцүүлэн явуулах бөгөөд хуралдааны дэгээ өөрөө тогтооно.

7.2.Ажлын хэсгийн хуралдааныг танхимаар зохион байгуулах бөгөөд Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу өндөржүүлсэн, эсхүл бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед Ажлын хэсгийн хуралдааныг цахимаар зохион

байгуулах асуудлыг Ажлын хэсэг шийдвэрлэж болно.

7.3.Ажлын хэсгийн ахлагч нь сонгон шалгаруулалтын бэлтгэлийг хангаж зохион байгуулах, хуралдааныг даргалах, Ажлын хэсгийн шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авах бөгөөд энэ журамд өөрөөр заагаагүй бол Ажлын хэсгийн гишүүний эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

7.4.Ажлын хэсгийн сонгон шалгаруулалтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

7.4.1.Байнгын хороонд хүсэлт гаргагчаас ирүүлсэн нэр дэвших тухай хүсэлт, холбогдох баримт бичгийг хянах;

7.4.2.хүсэлт гаргагчийг нэр дэвшигчээр бүртгэх эсэхийг шийдвэрлэх;

7.4.3.бүртгэл, сонгон шалгаруулалттай холбоотой гомдлыг шийдвэрлэх;

7.4.4.нэр дэвшигчдийг Ажлын хэсгийн гишүүдэд хуваарилж, илтгэгч гишүүнийг томилох;

7.4.5.нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, бүрдүүлэх, холбогдох байгууллагаас лавлагаа, мэдээлэл гаргуулан авах;

7.4.6.илтгэгч гишүүний тайланг хэлэлцэх;

7.4.7.нэр дэвшигчтэй хийх Ажлын хэсгийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, нэр дэвшигчийн талаар нэмэлт мэдээлэл авах;

7.4.8.нэр дэвшигчийг тодруулах нууц санал хураалт явуулах;

7.4.9.санал хураалтын дүнгээр нэр дэвшигчдийг эрэмбэлэх;

7.4.10.сонгон шалгаруулалтын үйл явц, дүнг нийтэд мэдээлэх;

7.4.11.Шүүхийн тухай хуулийн 77.4.5 дахь заалтад заасан тоог баримтлан нэр дэвшигчийг санал болгож, Ажлын хэсгийн тайлангийн хамт Байнгын хороонд хүргүүлэх.

7.5.Ажлын хэсгийн гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.5.1.сонгон шалгаруулалттай холбоотой асуудлаар холбогдох хууль тогтоомжийн хүрээнд санал гаргах;

7.5.2.санал хураалт явуулах үед зөвхөн өөрийн нэрийн өмнөөс санал өгөх;

7.5.3.хүсэлт гаргагч, нэр дэвшигчийн баримт бичиг, илтгэгч гишүүний тайлан болон бусад холбогдох мэдээлэлтэй танилцах;

7.5.4.Ажлын хэсгийн хуралдаан болон энэ журмын 7.4.5-д заасан хэлэлцүүлгийн үеэр Ажлын хэсгийн ахлагч, илтгэгч гишүүн, нэр дэвшигчээс асуулт асуух, шаардлагатай бол нэр дэвшигчийн талаарх нэмэлт мэдээлэл, лавлагааг холбогдох байгууллагаас гаргуулан авах талаарх саналыг ажлын хэсгийн ахлагчид гаргах;

7.5.5.илтгэгч гишүүнээр томилогдсон тохиолдолд хариуцсан нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, бүрдүүлэх;

7.5.6.Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан өөрийн санал, дүгнэлтийг тэмдэглэлд тусгуулах;

7.5.7.Шүүхийн тухай хууль болон энэ журамд заасан бусад эрх.

7.6.Ажлын хэсгийн гишүүний үүрэг:

7.6.1.үйл ажиллагаандаа Шүүхийн тухай хууль болон энэ журамд заасан зарчим, хугацааг мөрдөж ажиллах;

7.6.2.Ажлын хэсгийн хуралдаан, хэлэлцүүлэг, санал хураалт болон сонгон шалгаруулалтын бусад үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцох;

7.6.3.хүндэтгэн үзэх шалтгааны улмаас санал хураалтад оролцох боломжгүй бол энэ талаар Ажлын хэсгийн ахлагчид урьдчилан мэдэгдэх бөгөөд үндэслэл бүхий тайлбар, нотлох баримтыг өгөх;

7.6.4.Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлыг шийдвэрлэхэд санал өгөх эрхээ бусад гишүүнд шилжүүлэх, эсхүл бусад гишүүний өмнөөс санал өгөхгүй байх;

7.6.5.Ажлын хэсгийн хуралдаан, хэлэлцүүлгийн дэг, журмыг сахих;

7.6.6.хүсэлт гаргагч, нэр дэвшигчийг ялгаварлан гадуурхахгүй байх;

7.6.7.нэр дэвшигчийн талаарх баримт, мэдээллийг тал бүрээс нь судалж, дүгнэх;

7.6.8.шударга, хараат бусаар ажиллах;

7.6.9.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх бөгөөд ашиг сонирхлын зөрчил үүссэн бол Байнгын хороонд даруй мэдэгдэх;

7.6.10.сонгон шалгаруулалтад итгэх итгэлийг алдагдуулах зохисгүй үйлдэл гаргахгүй байх;

7.6.11.илтгэгч гишүүнээр томилогдсон тохиолдолд нэр дэвшигчийн талаарх баримт, мэдээллийг бүрэн судлах, тайлан бэлтгэх;

7.6.12.албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн албаны болон хүний хувийн мэдээллийн нууцыг хадгалах;

7.6.13.Ажлын хэсгийн гишүүний хувиар нэр дэвшигч нарын талаар урьдчилан дүгнэлт, байр суурийг олон нийтийн өмнө илэрхийлэхгүй байх;

7.6.14.Ажлын хэсгийн гишүүний эрх, үүргийг урвуулан ашиглахгүй байх;

7.6.15.Шүүхийн тухай хууль болон энэ журамд заасан бусад үүрэг.

7.7.Ажлын хэсгийн гишүүн нь нэр дэвшигчтэй Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.5 дахь заалтад заасан хамаарал бүхий этгээд байвал

энэ журмын тавдугаар хавсралтад заасан маягтын дагуу ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдлийг бөглөж, сонгон шалгаруулах ажиллагаанаас татгалзан гарна.

7.8.Ажлын хэсгийн гишүүн нь Шүүхийн тухай хууль болон энэ журамд заасан эрхийг зохих ёсоор хэрэгжүүлэх, үүргийг биелүүлэх, зөрчихгүй байх талаар энэ журмын дөрөвдүгээр хавсралтад заасан баталгааг гаргаж Байнгын хороонд хүлээлгэн өгнө.

7.9.Ажлын хэсгийн гишүүн энэ журамд заасан үүргийг биелүүлэлгүй зөрчсөн нь тогтоогдсон бол зөрчлийн үр дагаврыг харгалзан Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар дараах шийдвэрийг гаргана:

7.9.1.тухайн гишүүнд нээлттэй сануулга өгч, энэ тухай олон нийтэд мэдээлэх;

7.9.2.зөрчил нь ноцтой, эсхүл удаа дараа давтагдсан бол Ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс чөлөөлөх.

7.10.Ажлын хэсгийн хуралдааныг гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцож, Шүүхийн тухай хууль болон энэ журамд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

Найм.Нэр дэвшигчээр бүртгэх

8.1.Бүртгэл хааснаас хойш ажлын хоёр өдрийн дотор Ажлын хэсэг хуралдаж, хүсэлт гаргагчийн нэр дэвших тухай хүсэлт, холбогдох баримт бичгийг дараах асуудлаар хянан шалгана:

8.1.1.энэ журмын 5.1.1, эсхүл 5.1.2-т заасан баримт бичгийг бүрэн ирүүлсэн эсэх;

8.1.2.ирүүлсэн баримт бичиг нь энэ журмын 2.1, эсхүл 2.2-т заасан шаардлагад хэлбэрийн хувьд нийцэж байгаа эсэх;

8.1.3.хүсэлт гаргагч энэ журамд заасан хязгаарлалт, хориглолтод хамаарахгүй эсэх.

8.2.Ажлын хэсэг хүсэлт гаргагчийг нэр дэвшигчээр бүртгэхтэй холбоотойгоор дараах ажиллагааг хийнэ:

8.2.1.хүсэлт гаргагчийн баримт бичгийг ирүүлсэн дарааллаар энэ журмын 8.1-д заасныг хангасан эсэхийг нэг бүрчлэн хянан шалгана;

8.2.2.хүсэлт гаргагчаас ирүүлсэн баримт бичгийг хянан шалгахад энэ журмын 8.1-д заасныг хангаж байвал нэр дэвшигчээр бүртгэнэ;

8.2.3.хүсэлт гаргагчаас ирүүлсэн баримт бичгийг хянан шалгахад энэ журмын 8.1-д заасныг хангаагүй бол нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзана;

8.2.4.энэ журмын 8.2.2, 8.2.3-т заасан асуудлаар Ажлын хэсгийн гишүүдийн санал зөрсөн бол санал хураалтаар шийдвэрлэнэ;

8.2.5.Ажлын хэсгийн ахлагч нэр дэвшигчээр бүртгэх ажиллагааны үр дүн, үндэслэлийг Ажлын хэсгийн хуралдаанд танилцуулж, Ажлын хэсгийн шийдвэрийг энэ журмын 8.3-т заасан тэмдэглэлээр баримтжуулна;

8.2.6.энэ журмын 8.2.5-д заасан тэмдэглэлийг Ажлын хэсгийн хуралдаанд оролцсон гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

8.3.Энэ журмын 8.2-т заасны дагуу хүсэлт гаргагчийг нэр дэвшигчээр бүртгэх ажиллагааг хийхдээ тэмдэглэл хөтлөх бөгөөд энэ нь Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлийн бүрэлдэхүүн хэсэг байна. Нэр дэвшигчээр бүртгэх ажиллагааны тэмдэглэлд дараах мэдээллийг тусгана:

8.3.1.нэр дэвшигчээр бүртгэх ажиллагаа эхэлсэн, дууссан огноо, цаг;

8.3.2.нэр дэвшигчээр бүртгэх ажиллагаанд оролцсон Ажлын хэсгийн гишүүд, байлцсан этгээдийн овог, нэр, албан тушаал;

8.3.3.хянан шалгасан хүсэлт гаргагчийн жагсаалт;

8.3.4.нэр дэвшигчээр бүртгэсэн жагсаалт;

8.3.5.нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан жагсаалт, татгалзсан үндэслэл;

8.3.6.үйл ажиллагааны нэгдсэн тойм.

8.4.Энэ журмын 8.2.3-т заасны дагуу нэр дэвшигчээр бүртгээгүй бол энэ тухай хүсэлт гаргагчид ажлын нэг өдрийн дотор бичгээр /шуудан, цахим шуудан, үүрэн холбооны мессеж/, эсхүл түүний зөвшөөрснөөр аман хэлбэрээр мэдэгдэж, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Хүсэлт гаргагч өөрийг нь нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан үндэслэлийг бичгээр өгөхийг шаардах эрхтэй бөгөөд Ажлын хэсэг энэ тухай тайлбарыг өгнө.

8.5.Хүсэлт гаргагч нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан тухай шийдвэрийг энэ журмын 8.4 заасны дагуу мэдсэнээс хойш ажлын хоёр өдрийн дотор Ажлын хэсэгт гомдол гаргаж болно.

8.6.Энэ журмын 8.5-д заасны дагуу хүсэлт гаргагч гомдол гаргасан бол Ажлын хэсэг ажлын хоёр өдрийн дотор хуралдаж, гомдлыг шийдвэрлэнэ. Хүсэлт гаргагч энэ асуудлаар Ажлын хэсэгт дахин гомдол гаргахгүй. Энэ талаар хүсэлт гаргагчид энэ журмын 8.4-т заасныг баримтлан мэдэгдэнэ.

8.7.Энэ журмын 8.2.3-т заасны дагуу нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсаны улмаас тухайн орон тоонд нэг ч нэр дэвшигч бүртгэгдээгүй бол Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын зарыг дахин нийтэд мэдээлэх саналыг Байнгын хороонд гаргаж болно.

Ес.Нэр дэвшигчийг нийтэд мэдээлэх, асуулт, санал хүлээн авах

9.1.Энэ журмын 8.2-т заасны дагуу нэр дэвшигчээр бүртгэсэн, эсхүл энэ журмын 8.6-д заасны дагуу гомдлыг шийдвэрлэснээс хойш ажлын нэг өдрийн дотор бүртгэсэн нэр дэвшигчдийн нэрс, нэр дэвших тухай хүсэлт, холбогдох бусад мэдээллийг энэ журмын 4.3-т заасныг баримтлан нийтэд мэдээлнэ.

9.2.Энэ журмын 9.1-д заасны дагуу нийтэд мэдээлэх баримт бичиг,

мэдээллээс хүний эмзэг мэдээлэл болон гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаарыг хасна.

9.3.Энэ журмын 9.1-д заасан нэр дэвшигчийг нийтэд мэдээлэхдээ нэр дэвшигчтэй холбоотой асуулт, саналыг биечлэн хүлээн авах хаяг, шуудангийн хаяг, цахим шуудангийн хаягийг мөн адил нийтэд мэдээлнэ.

9.4.Байнгын хорооны ажлын алба сонирхогч этгээдээс ирүүлсэн нэр дэвшигчтэй холбоотой асуулт, саналыг энэ журмын 9.1-д заасны дагуу нийтэд мэдээлснээс хойш 14 хоногийн хугацаанд цаасан, эсхүл цахим хэлбэрээр хүлээн авч, огноо, цагийг тэмдэглэн, ирүүлсэн дарааллын дагуу бүртгэлийн дугаар олгоно.

9.5.Байнгын хорооны ажлын алба нэр дэвшигчтэй холбоотой сонирхогч этгээдээс ирүүлсэн асуулт, саналыг Ажлын хэсэгт хүргүүлэх бөгөөд асуулт, саналыг агуулгаар нь ангилж, давхардсан агуулгатай асуулт, саналыг нэгтгэн боловсруулж болно.

9.6.Нэр дэвшигчийн болон гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдсан, эсхүл сонгон шалгаруулалттай холбоогүй агуулгатай мэдээллийг нийтэд ил тод байршуулахгүй бөгөөд нэр, хаяг тодорхойгүй асуулт, саналыг бүртгэхгүй.

Арав.Нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, бүрдүүлэх

10.1.Энэ журмын 9.1-д заасны дагуу нийтэд мэдээлснээс хойш ажлын нэг өдрийн дотор Ажлын хэсэг Шүүхийн тухай хуулийн 77.4.2 дахь заалтад заасны дагуу дараах байдлаар илтгэгч гишүүнийг томилно:

10.1.1.Нэг нэр дэвшигчийг хоёр Ажлын хэсгийн гишүүн хариуцаж ажиллах байдлаар хуваарилна;

10.1.2.Ажлын хэсгийн ахлагч энэ журмын 10.1.1-д заасны дагуу нэр дэвшигчдийн нийт тоог хоёроор үржүүлэн тооцож, уг тоог Ажлын хэсгийн бусад гишүүдийн тоонд хуваах байдлаар нэг гишүүнд ногдох нэр дэвшигчийн тоог тогтооно;

10.1.3.илтгэгч гишүүдэд хуваарилагдах нэр дэвшигчийн тоо тэнцвэртэй байх бөгөөд тооны зөрүү нэгээс илүүгүй байна;

10.1.4.Ажлын хэсгийн ахлагч Ажлын хэсгийн бусад гишүүнээс хэн нэг дэвшигчтэй холбоотойгоор Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.11 дахь заалтад заасан ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал бий болсон эсэхийг тодруулна.

10.1.5.Ажлын хэсгийн гишүүн нь энэ журмын 10.1.4-д заасан нөхцөл байдал бий болсон талаар Ажлын хэсгийн ахлагчид мэдэгдсэн бол Ажлын хэсгийн ахлагч тухайн гишүүнээс энэ журмын зургаадугаар хавсралтад заасан маягтын дагуу ашиг сонирхлын зөрчлийн тайлбарыг гаргуулан авч, тухайн нэр дэвшигчийг хариуцан ажиллахаар хуваарилагдахгүй байх арга хэмжээг авна.

10.1.6.илтгэгч гишүүдэд нэр дэвшигчийг хуваарилах ажиллагааг урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй сонголтын аргаар цахим систем ашиглан, эсхүл цаасан дээр нэр дэвшигчдийн нэрийг бичиж Ажлын хэсгийн гишүүдээр сугалуулах байдлаар явуулах бөгөөд аль хэлбэрээр явуулахыг Ажлын хэсгийн гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ;

10.1.7.энэ журмын 10.1.6-д заасан илтгэгч гишүүдэд нэр дэвшигчийг хуваарилах ажиллагааг хоёр удаа явуулах бөгөөд дараах байдлаар явуулна:

10.1.7.а.эхний удаад нийт нэр дэвшигчдийг Ажлын хэсгийн гишүүд /Ажлын хэсгийн ахлагчаас бусад/-д хуваарилах;

10.1.7.б.дараагийн удаад илтгэгч гишүүнд хуваарилагдсан нэр дэвшигчийг давхцуулахгүйгээр Ажлын хэсгийн бусад гишүүд /Ажлын хэсгийн ахлагчаас бусад/-д хуваарилах.

10.1.8.нэр дэвшигчийг хариуцан ажиллахаар энэ журмын 10.1.7-д заасны дагуу эхний удаад хуваарилагдсан бол нэг дугаартай, дараагийн удаад хуваарилагдсан бол хоёр дугаартай илтгэгч гишүүн болно.

10.1.9.Ажлын хэсгийн гишүүн илтгэгч гишүүнийг томилох ажиллагааны үеэр байгаагүй нь илтгэгч гишүүнийг томилох ажиллагааг зогсоох үндэслэл болохгүй бөгөөд бусад гишүүдийн оролцоотойгоор үргэлжлүүлнэ;

10.1.10.Ажлын хэсгийн ахлагч илтгэгч гишүүнийг томилох үйл ажиллагааны үйл явц, үр дүнг Ажлын хэсгийн гишүүдэд танилцуулснаар илтгэгч гишүүнийг томилсонд тооцно;

10.1.11.илтгэгч гишүүн энэ журмын 10.1.5-д заасны дагуу өөрт хуваарилагдсан нэр дэвшигчийг өөрчлөх хүсэлт гаргахгүй;

10.1.12.илтгэгч гишүүнийг томилох ажиллагааны үр дүнг энэ журмын 10.4-т заасан тэмдэглэлээр баримтжуулж, тэмдэглэлийг Ажлын хэсгийн ахлагч гарын үсэг зурж баталгаажуулна.

10.2.Энэ журмын 10.1-д заасны дагуу илтгэгч гишүүнийг томилох үйл ажиллагаанд Ажлын хэсгийн гишүүд хяналт тавьж ажиллана.

10.3.Энэ журмын 10.1-д заасны дагуу илтгэгч гишүүнийг томилох үйл ажиллагааг явуулахдаа тэмдэглэл хөтлөх бөгөөд энэ нь Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлийн бүрэлдэхүүн хэсэг байна. Илтгэгч гишүүнийг томилох ажиллагааны тэмдэглэлд дараах мэдээллийг тусгаж, Ажлын хэсгийн гишүүдэд танилцуулна.

10.3.1.илтгэгч гишүүнийг томилох ажиллагаа эхэлсэн, дууссан огноо, цаг;

10.3.2.илтгэгч гишүүнийг томилох ажиллагаанд оролцсон, байлцсан этгээдийн овог, нэр, албан тушаал;

10.3.3.нэг гишүүнд хуваарилагдах нэр дэвшигчийн тоо;

10.3.4.нэр дэвшигчдийг Ажлын хэсгийн гишүүдэд хуваарилах ажиллагааг явуулсан арга, хэлбэр;

10.3.5.ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал бий болсон эсэх;

10.3.6.илтгэгч гишүүнийг томилох ажиллагааны үр дүн.

10.4.Илтгэгч гишүүн тус бүр дараах ажиллагааг явуулж, мэдээлэл бүрдүүлнэ:

10.4.1.энэ журмын 5.1.1, эсхүл 5.1.2-т заасны дагуу ирүүлсэн хүсэлт, баримт бичгийг судлах, үнэн зөв эсэхийг нягтлах;

10.4.2.олон нийтэд өгсөн мэдээллийг судалж, дүгнэх;

10.4.3.энэ журмын 9.4-т заасны дагуу сонирхогч этгээдээс ирүүлсэн асуулт, саналыг судлах;

10.4.4.нэр дэвшигчийн талаарх гурваас доошгүй хүний тодорхойлолт /Тодорхойлогч нь нэр дэвшигчийн одоогийн, эсхүл өмнөх ажлын байрны шууд удирдах албан тушаалтан, эсхүл энэ журмын 2.1, эсхүл 2.2-т заасан шаардлага хангасан эсэх тухай бодит мэдээлэл өгөх боломжтой бусад хүн байна/ авах;

10.4.5.эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас баримт, мэдээлэл гаргуулан авах;

10.4.6.хэвлүүлсэн бүтээл /ном, өгүүлэл, тайлан зэрэг/-ийг судалж дүгнэх;

10.4.7.нэр дэвшигч энэ журмын 2.1, эсхүл 2.2-т заасан шаардлагыг хангаж буй эсэхийг тодруулах зорилгоор түүний талаар мэдээлэл өгөх боломжтой зургаагаас доошгүй хүн /нэр дэвшигчийн удирдлага дор нь, түүнийг удирдаж, хамтран ажиллаж байсан, эсхүл байгаа зэрэг/-тэй ярилцлага хийх;

10.4.8.нэр дэвшигчтэй ярилцлага хийх, түүнээс нэмэлт мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах;

10.4.9.нэр дэвшигчийн талаар дүгнэлт хийхэд зайлшгүй шаардлагатай мэдээллийг бусад хэлбэрээр цуглуулах.

10.5.Энэ журмын 10.4.4-т заасан тодорхойлогч нь дараах мэдээллийг тодорхойлолтод бүрэн дүүрэн, үнэн зөвөөр тусгаж, өөрийн нэр, эрхэлж байгаа ажил, ажлын газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаягийг бичиж, тодорхойлолтыг дугтуйнд хийж, гарын үсэг зурж баталгаажуулна:

10.5.1.нэр дэвшигчийг Ерөнхий зөвлөлийн, эсхүл Сахилгын хорооны гишүүнээр ажиллахад тохирсон эсэх;

10.5.2.нэр дэвшигч нь энэ журмын 2.1, эсхүл 2.2-т заасан шаардлагыг хангасан эсэх;

10.5.3.нэр дэвшигчтэй хэдий хугацаанд, ажил хэргийн ямар харилцаатай байсан тухай.

10.6.Илтгэгч гишүүн энэ журамд заасны дагуу нэр дэвшигч болон бусад этгээдтэй ярилцлагыг биечлэн, цахим, эсхүл бусад тохиромжтой хэлбэрээр хийж

болох бөгөөд ярилцлагын огноо, цаг хугацаа, гол агуулгын тухай тэмдэглэл хөтөлж, товчлолыг тайланд тусгана.

10.7.Илтгэгч гишүүн нэр дэвшигчийн талаар бүрдүүлсэн мэдээлэлд сөрөг агуулга байвал тухайн нэр дэвшигчид танилцуулж, тайлбар өгөх боломж олгох бөгөөд тухайн мэдээллийг итгэмжлэн өгсөн хүний нэр, эсхүл түүнийг таних шинжийн талаар нэр дэвшигчид мэдэгдэхийг хориглоно.

10.8.Байнгын хорооны ажлын албанд нэр дэвшигчийн талаарх мэдээллийг иргэд, олон нийтийн байгууллагаас ирүүлсэн бол Байнгын хорооны ажлын алба энэ талаар илтгэгч гишүүнд тухай бүр танилцуулна.

10.9.Нэр дэвшигч энэ журмын 2.1, эсхүл 2.2-т заасан шаардлагыг хангасан тухай нэмэлт мэдээлэл, баримт бичгийг өөрийн санаачилгаар илтгэгч гишүүнд гаргаж өгч болно.

10.10.Илтгэгч гишүүн тус бүр энэ журмын 10.1-д заасны дагуу хуваарилалт хийгдсэнээс хойш 14 хоногийн дотор нэр дэвшигчийн талаарх мэдээллийг бүрдүүлж, Ерөнхий зөвлөлийн, эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүнд тавих шаардлага тус бүрийг хангасан эсэх талаар дүгнэлт, үндэслэл бүхий дэлгэрэнгүй тайланг энэ журмын долоодугаар, эсхүл наймдугаар хавсралтад заасан загварын дагуу өөрөө бичиж эхний байдлаар бэлтгэнэ.

10.11.Нэг нэр дэвшигчийг хариуцаж ажиллахаар хуваарилагдсан нэг, хоёр дугаартай илтгэгч гишүүд нь бие биеэсээ хараат бусаар, бие даан ажиллах бөгөөд энэ журамд заасан үйл ажиллагааг тус тусдаа хэрэгжүүлнэ.

10.12.Нэг, хоёр дугаартай илтгэгч гишүүд нэр дэвшигчийн талаар харилцан мэдээлэл солилцож болно.

10.13.Энэ журмын 10.1-д заасан илтгэгч гишүүнийг томилох ажиллагаа дууссаны дараа нөхөн томилогдсон Ажлын хэсгийн гишүүнийг өмнө нь тухайн чиг үүргийг хэрэгжүүлж байсан гишүүний оронд илтгэгч гишүүнээр томилж болно.

10.14.Нэр дэвшигчийн талаарх лавлагаа авах, нэмэлт мэдээлэл, баримт, тайлбар гаргуулах зэрэг ажиллагааг Ажлын хэсгийн ахлагч өөрийн санаачилгаар эсхүл илтгэгч гишүүний хүсэлтийн дагуу нэгдсэн журмаар зохион байгуулж болно.

Арван нэг.Ажлын хэсгийн хэлэлцүүлэг зохион байгуулах

11.1.Энэ журмын 10.10-д заасан хугацаа дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор нэр дэвшигчийн талаар бүрдүүлсэн мэдээллийг нягтлах, тодруулах зорилгоор Ажлын хэсэг хэлэлцүүлэг зохион байгуулна.

11.2.Ажлын хэсгийн хэлэлцүүлэг нь нэр дэвшигчийг тодруулах болон бүртгэлээс хасах асуудлаар шийдвэр гаргахгүй бөгөөд зөвхөн Ажлын хэсгийн гишүүд нэр дэвшигчээс мэдээлэл авах, тодруулах, мэдээллийг баталгаажуулахад чиглэнэ.

11.3.Ажлын хэсэг зургаагаас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хэлэлцүүлгийг хийх бөгөөд Ажлын хэсгийн ахлагч удирдана.

11.4.Ажлын хэсгийн хэлэлцүүлгийг зохион байгуулахаас ажлын гурваас доошгүй өдрийн өмнө энэ журмын 4.3-т заасныг баримтлан нийтэд мэдээлэх бөгөөд энэ талаар нэр дэвшигчдэд бүртгүүлсэн утасны дугаар, эсхүл цахим шуудангийн хаягаар мэдэгдэнэ.

11.5.Ажлын хэсгийн гишүүд хэлэлцүүлгийн үеэр энэ журмын 2.1, эсхүл 2.2-т заасан шаардлагад үндэслэсэн асуултыг нэр дэвшигчээс асууж, хариулт авна. Ялгаварлан гадуурхсан, эсхүл доромжилсон асуулт асуухыг хориглоно.

11.6.Ажлын хэсгийн хэлэлцүүлгийг зохион байгуулснаас хойш ажлын дөрвөн өдрийн дотор илтгэгч гишүүн тус бүр нэр дэвшигчийн талаарх дэлгэрэнгүй тайлан /энэ журмын 10.10-д заасан тайлан/-даа Ажлын хэсгийн хэлэлцүүлгийн үйл явц, зайлшгүй шаардлагатай нэмэлт мэдээллийг тусгаж эцэслэнэ.

11.7.Нэг дугаартай илтгэгч гишүүн, эсхүл нэг, хоёр дугаартай илтгэгч гишүүд харилцан тохиролцсоны үндсэн дээр хоёр дугаартай илтгэгч гишүүн энэ журмын 11.6-д заасан тайланг нэгтгэсэний дараа илтгэгч гишүүд гарын үсэг зурах бөгөөд тайланг цахим хэлбэрээр Ажлын хэсгийн бусад гишүүдэд хүргүүлнэ.

11.8.Энэ журмын 11.7-д заасан илтгэгч гишүүн нь нэр дэвшигчийн талаарх тайланг нэгтгэхдээ нөгөө илтгэгч гишүүний тайлангийн агуулгыг түүний зөвшөөрөлгүйгээр өөрчилж болохгүй.

Арван хоёр.Нэр дэвшигчийг тодруулах

12.1.Энэ журмын 11.6-д заасан хугацаа дууссанаас хойш ажлын дөрвөн өдрийн дотор Ажлын хэсэг дараах журмаар хуралдаж нэр дэвшигчийг Ерөнхий зөвлөлийн, эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэх эсэхийг шийдвэрлэнэ:

12.1.1.Ажлын хэсгийн хуралдаанд энэ журмын 10.13-д заасан илтгэгч гишүүн тус бүр өөрт хуваарилагдсан нэр дэвшигчийн талаарх дэлгэрэнгүй тайланг танилцуулах бөгөөд бусад гишүүн тайлантай холбоотой асуултыг нэг, хоёр дугаартай илтгэгч гишүүдээс асууж болно;

12.1.2.нэр дэвших тухай хүсэлт, холбогдох баримт бичиг, бүрдүүлсэн мэдээлэл, илтгэгч гишүүдийн дэлгэрэнгүй тайланд үндэслэн нэр дэвшигч нь энэ журмын 2.1, эсхүл 2.2-т заасан шаардлагыг хэрхэн хангаж байгаа талаар Ажлын хэсгийн гишүүн бүр саналаа хэлж зөвлөлдөнө. Ажлын хэсэг нэр дэвшигчийг үнэлэхэд нотолгоогүй мэдээллийг ашиглахгүй;

12.1.3.Ажлын хэсгийн гишүүн тус бүр нэр дэвших тухай хүсэлт, холбогдох баримт бичиг, бүрдүүлсэн мэдээлэл, илтгэгч гишүүний дэлгэрэнгүй тайланд дүгнэлт хийсний үндсэн дээр Ерөнхий зөвлөлийн, эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүнд тавих шаардлагыг хамгийн сайн хангасан гэж дүгнэсэн Шүүхийн тухай хуулийн 77.4.5 дахь хэсэгт заасан тоонд харгалзах нэр дэвшигчид саналаа өгнө.

12.2.Нэр дэвшигчийг тодруулах санал хураалтыг Шүүхийн тухай хуулийн 77.4.4 дэх заалтад заасны дагуу нууцаар явуулах бөгөөд дараах журмыг баримтална:

12.2.1.Ажлын хэсэг нууц санал хураалтыг цахим системээр, эсхүл саналын хуудсаар явуулах эсэхийг шийдвэрлэнэ;

12.2.2.Ажлын хэсгийн гишүүн бүр нэр дэвшигч тус бүрээр дэмжинэ, эсхүл дэмжихгүй санал өгнө;

12.2.3.нууц санал хураалтыг цахим систем ашиглан явуулах бол санал хураалтын дүнг тэр даруй дэлгэцээр харуулах бөгөөд санал өгсөн гишүүдийн нэрс хуралдааны цахим системд хадгалагдахгүй байдлаар зохион байгуулна;

12.2.4.нууц санал хураалтыг саналын хуудсаар явуулах бол Ажлын хэсгийн гурван гишүүнээс бүрдсэн тооллогын комисс байгуулж, саналын хуудсыг саналын хайрцгаар хураах байдлаар зохион байгуулна;

12.2.5.саналын хайрцгаар хураасан нууц санал хураалтыг тооллогын комисс бусад гишүүдийн хяналт дор тоолно;

12.2.6.ямар ч тохиолдолд нууц санал хураалтыг дахин явуулахгүй /нууц санал хураалтын дүнгээр аль ч нэр дэвшигч олонхын санал аваагүй, эсхүл олонхын санал авсан нэр дэвшигчийн тоо сул орон тоотой харгалзах тооноос дутуу, эсхүл олонхын санал авсан нэр дэвшигчийн тоо сул орон тоонд хүрсэн боловч дараагийн хоёр хүртэлх нэр дэвшигч олонхын санал аваагүй гэсэн шалтгаанаар дахин санал хураалт явуулахыг хориглоно/;

12.2.7.Ажлын хэсгийн ахлагч нууц санал хураалтын дүнг Ажлын хэсгийн гишүүдэд танилцуулснаар нууц санал хураалтыг дууссанд тооцно.

12.3.Нууц санал хураалтын дүнгээр Ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчдийг дараах байдлаар эрэмбэлнэ:

12.3.1.Ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчдийн жагсаалтыг гаргана;

12.3.2.энэ журмын 12.3.1-д заасан жагсаалтаас хамгийн олон санал авсан нэр дэвшигчээс эхлэн саналын тоогоор буурах дарааллаар эрэмбэлнэ;

12.3.3.энэ журмын 12.3.2-т заасны дагуу эрэмбэлэхэд саналын тоо тэнцсэн нэр дэвшигчийн тоо нь Шүүхийн тухай хуулийн 77.4.5 дахь заалтад заасан тооноос илүү гарсан бол зөвхөн саналын тоо нь тэнцсэн нэр дэвшигчдийг эрэмбэлэх зорилгоор нэг удаа дахин санал хураалт явуулах бөгөөд дахин санал хураалтыг энэ журмын 12.2-т заасныг баримтлан явуулна;

12.3.4.дахин санал хураалтын дүн нь эхний санал хураалтын дүнгээр өмнө эрэмбэлэгдсэн нэр дэвшигчийн эрэмбийг өөрчлөх үндэслэл болохгүй бөгөөд зөвхөн саналын тоо нь тэнцсэн эрэмбэд аль нэр дэвшигчийг эрэмбэлэх асуудлыг өөрчлөх үндэслэл болно;

12.3.5.дахин санал хураалтын дүнгээр саналын тоо нь дахин тэнцсэн бол энэ талаар Ажлын хэсгийн тайланд дурдаж, Байнгын хороонд хүргүүлнэ;

12.3.6.Ажлын хэсгийн ахлагч олонхын санал авсан нэр дэвшигчдийг саналын дарааллаар эрэмбэлсэн жагсаалтыг Ажлын хэсгийн гишүүдэд танилцуулж, энэ журмын 12.5-д заасан тэмдэглэлээр баримтжуулна;

12.3.7.энэ журмын 12.3.6-д заасан тэмдэглэлийг Ажлын хэсгийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

12.4.Энэ журмын 12.2, 12.3-т заасан үйл ажиллагаанд Ажлын хэсгийн гишүүд хяналт тавьж ажиллана.

12.5.Энэ журмын 12.2, 12.3-т заасан үйл ажиллагааг явуулахдаа нэг тэмдэглэл хөтлөх бөгөөд энэ нь Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлийн бүрэлдэхүүн хэсэг байна. Нэр дэвшигчийг тодруулах ажиллагааны тэмдэглэлд дараах мэдээллийг тусгана:

12.5.1.үйл ажиллагаа эхэлсэн, дууссан огноо, цаг;

12.5.2.санал хураалтад оролцсон Ажлын хэсгийн гишүүд, байлцсан этгээдийн овог, нэр, албан тушаал;

12.5.3.нууц санал хураалтыг явуулсан арга, хэлбэр;

12.5.4.нууц санал хураалтын дүн;

12.5.5.олонхын санал авсан нэр дэвшигчдийн жагсаалт;

12.5.6.нэр дэвшигчдийг саналын тоогоор эрэмбэлсэн жагсаалт;

12.5.7.дахин санал хураалт явуулсан эсэх;

12.5.8.үйл ажиллагааны нэгдсэн тойм.

12.6.Энэ журмын 12.3-т заасны дагуу олонхын санал авсан нэр дэвшигчийн талаарх Ажлын хэсгийн тайланг дараах агуулгаар бэлтгэж /энэ журмын есдүгээр, эсхүл аравдугаар хавсралтаар баталсан загварын дагуу/, хуралдаанд оролцсон Ажлын хэсгийн гишүүд гарын үсэг зурна:

12.6.1.нэр дэвшигчийн товч танилцуулга;

12.6.2.сонгон шалгаруулалт, түүний үе шат Шүүхийн тухай хууль болон энэ журмын дагуу хэрхэн явагдсан тухай;

12.6.3.нэр дэвшигч нь энэ журмын 2.1, эсхүл 2.2-т заасан шаардлагыг хэрхэн хангаж Ерөнхий зөвлөлийн, эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүн болоход хамгийн сайн тохирно гэж дүгнэсэн үндэслэл.

12.7.Энэ журмын 12.6-д заасан Ажлын хэсгийн тайланд нэр дэвшигчийн эмзэг мэдээлэл болон гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн мэдээлэлд хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, таних шинжийг бичихгүй.

12.8.Энэ журмын 12.2-т заасан санал хураалтаар аль ч нэр дэвшигч олонхын санал аваагүй бол тухайн сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах тухай зарыг нийтэд дахин мэдээлэх саналыг Ажлын хэсэг Байнгын хороонд гаргана.

12.9.Ажлын хэсгийн хуралдаан, түүний тэмдэглэл, илтгэгч гишүүний дэлгэрэнгүй тайлан зэрэг нь албаны нууцад хамаарах бөгөөд холбогдох хууль тогтоомжоор хамгаалагдана.

Арван гурав.Нэр дэвшигчийг санал болгох

13.1.Энэ журмын 12.1-д заасан хуралдаанаас хойш ажлын гурван өдрийн дотор Ажлын хэсэг олонхын санал авсан, саналын дарааллаар эрэмбэлэгдсэн, Шүүхийн тухай хуулийн 77.4.5 дахь заалтад заасан нэр дэвшигчдийг Байнгын хороонд санал болгоно.

13.2.Ажлын хэсэг энэ журмын 13.1-д заасан нэр дэвшигчдийн нэр, тэдгээрийн талаарх Ажлын хэсгийн тайлан, холбогдох баримт бичгийг Байнгын хороонд хүргүүлнэ.

Арван дөрөв.Бусад

14.1.Энэ журмын 8.6, 12.8-д заасны дагуу Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын зарыг дахин нийтэд мэдээлэх саналыг ажлын гурван өдрийн дотор Байнгын хороонд гаргана. Байнгын хороо уг саналыг ажлын хоёр өдрийн дотор Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

14.2.Энэ журмын 14.1-д заасны дагуу Байнгын хорооны шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлж, энэ үеэс эхлүүлэн Шүүхийн тухай хууль болон энэ журамд заасан хугацаанд сонгон шалгаруулалтыг явуулна.

14.3.Байнгын хорооны ажлын алба сонгон шалгаруулалттай холбогдох баримт бичгийг зохих журмын дагуу бүрдүүлж, Ажлын хэсгийн ахлагчаар хянуулан Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын архивт хүлээлгэн өгнө.

14.4.Энэ журмыг баталснаас хойш ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудас /www.parliament.mn/-д хавсралтуудын хамт байршуулна.

---oO---

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн
байнгын хорооны 2026 оны 04 дугаар
сарын 29 -ны өдрийн 04 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮГЧ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв, бүрэн дүүрэн бичнэ. Компьютерын программ ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралтыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ. Мөн, нэр дэвших тухай хүсэлтийг Word-ын файлаар цахим шуудан /сонгон шалгаруулах тухай зард заасан хаяг/-аар тус Байнгын хороонд явуулна.

НЭГ. ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

1.1	Эцэг/эхийн нэр: Ургийн овог: Нэр: Хүйс: Төрсөн он: Төрсөн газар: Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг:
1.2	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/.
1.3	Насны дээд хязгаар Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/.
1.4	Шүүгчийн албан тушаал Шүүгчээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, аль шүүхэд ямар хугацаанд шүүгчээр ажиллаж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.
1.5	Улс төрийн болон намын удирдах албан тушаал Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу /тийм,

	<p>эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
1.6	<p>Эрүүгийн хариуцлага Эрүүгийн хариуцлага хүлээж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
1.7	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
1.8	<p>Монгол Улсын Их Хурлаас Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилохоос татгалзаж байсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшсэн боловч Монгол Улсын Их Хурлаас томилохоос татгалзаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих/.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>

ХОЁР.ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний хувьд хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /тайлбарыг 500-1000 үгэнд багтаана/</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
-----	---

ГУРАВ.МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Д/д	Шалгуур үзүүлэлт
3.1	<p>Эрх зүйч мэргэжлээр ажилласан байдал Хүсэлт гаргагч нь эрх зүйч мэргэжлээр ажилласан байдлын талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар тодорхойлон бичих бөгөөд ажил тус</p>

	<p>бүрийг эрхэлж байсныг нотлох баримтыг хавсаргана. Ажил тус бүрийг тодорхойлохдоо дараах мэдээллийг заавал бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолтын гол агуулга; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/; -тухайн албан тушаал эрхэлж байхдаа хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан таваас доошгүй хүний нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/. <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
<p>3.2</p>	<p>Эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажил</p> <p>Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Ингэхдээ ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
<p>3.3</p>	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</p> <p>Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн, эсхүл хүний эрхийн чиглэлээр ажилладаг бусад холбоо, байгууллагын гишүүн бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар нэрлэн бичиж, гишүүнчлэл тус бүрийг нотлох баримтыг хавсаргана.</p> <ul style="list-style-type: none"> -Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана. -Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүргийн нэр, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичнэ. <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>

ДӨРӨВ.ХУУЛЬ ЗҮЙН ӨНДӨР МЭРГЭШИЛ

<p>4.1</p>	<p>Хууль зүйн өндөр мэргэшил</p> <p>Хүсэлт гаргагчийг хууль зүйн өндөр мэргэшилтэй /хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай, мэргэжлийн өндөр ёс зүйтэй/ гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлох бөгөөд үйл ажиллагаа тус бүрийг явуулсныг нотлох баримтыг хавсаргана. Ийм үйл ажиллагаа тус бүрийн талаар дараах мэдээллийг заавал бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;
-------------------	---

	<p>-үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр /нэрс аль болох давцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;</p> <p>-тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан гурваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;</p> <p>-хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
<p>4.2</p>	<p>Байгаа бол хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл</p> <p>-Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-Сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.</p> <p>-Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.</p> <p>Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх цахим холбоосыг тусгана.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
<p>4.3</p>	<p>Байгаа бол Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл (гэрчилгээ)</p> <p>Хуульчийн мэргэжлийн, эсхүл өмгөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зэрэг хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагааны зөвшөөрөлтэй юу, эсхүл ийм зөвшөөрөлтэй байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг зөвшөөрлийг ямар хугацаанд эзэмшиж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
<p>4.4</p>	<p>Байгаа бол магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэг цолны талаарх мэдээлэл</p> <p>Суралцаж төгссөн их, дээд сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, эрдмийн зэрэг, цол авсан огноог бичнэ.</p>

4.5	<p>Сахилгын шийтгэл Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж, эсхүл огцорч байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
------------	--

Хавсралт:

Нэр дэвших тухай хүсэлтэд журмын 5.1.1-д заасан дараах баримт бичгийг хавсаргана:

- төрийн албан хаагчийн анкет;
- иргэний үнэмлэхийн хуулбар;
- нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;
- эрх зүйн бакалаврын, эсхүл түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар;
- хууль зүйн өндөр мэргэшилтэй гэдгийг нотлон харуулсан үйл ажиллагааны талаарх баримт;
- эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласныг нотлох баримт;
- энэхүү загварт заасан баримт бичиг;
- холбогдох бусад баримт.

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр:.....

Өөрийн нэр:

Гарын үсэг:

Он, сар, өдөр:

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн
байнгын хорооны 2026 оны 04 дугаар
сарын 29 -ны өдрийн 0.4 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ШҮҮГЧ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв, бүрэн дүүрэн бичнэ. Компьютерын программ ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралтыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ. Мөн, нэр дэвших тухай хүсэлтийг Word-ын файлаар цахим шуудан /сонгон шалгаруулах тухай зард заасан хаяг/-аар тус Байнгын хороонд явуулна.

НЭГ. ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

1.1	Эцэг/эхийн нэр: Ургийн овог: Нэр: Хүйс: Төрсөн он: Төрсөн газар: Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг:
1.2	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/.
1.3	Насны дээд хязгаар Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/.
1.4	Улс төрийн болон намын удирдах албан тушаал Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.
1.5	Шүүгчийн албан тушаал

	<p>Шүүгчээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, аль шүүхэд ямар хугацаанд шүүгчээр ажиллаж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
1.6	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
1.7	<p>Шүүхийн захиргааны байгууллагын ажилтан Шүүхийн захиргааны байгууллагын ажилтны ажил, албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг ажил, албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
1.8	<p>Өмгөөлөгч Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй юу, эсхүл ийм эрхтэй байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг эрхийг ямар хугацаанд эдэлж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
1.9	<p>Прокурор Прокурорын албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
1.10	<p>Эрүүгийн хариуцлага Эрүүгийн хариуцлага хүлээж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>.....</p>

1.11	Шүүхийн сахилгын хорооны гишүүн Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.

1.12	Монгол Улсын Их Хурлаас Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнээр томилохоос татгалзаж байсан Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшсэн боловч Монгол Улсын Их Хурлаас томилохоос татгалзаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих/.

ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүний хувьд хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /тайлбарыг 500-1000 үгэнд багтаана/

ГУРАВ.МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Д/д	Шалгуур үзүүлэлт
3.1	Эрх зүйч мэргэжлээр ажилласан байдал Хүсэлт гаргагч нь эрх зүйч мэргэжлээр ажилласан байдлын талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар тодорхойлон бичих бөгөөд ажил тус бүрийг эрхэлж байсныг нотлох баримтыг хавсаргана. Ажил тус бүрийг тодорхойлохдоо дараах мэдээллийг заавал бичнэ: -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолтын гол агуулга; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/; -тухайн албан тушаал эрхэлж байхдаа хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан таваас доошгүй хүний нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/.

<p>3.2</p>	<p>Эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажил Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Ингэхдээ ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</p>
<p>3.3</p>	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн, эсхүл хүний эрхийн чиглэлээр ажилладаг бусад холбоо, байгууллагын гишүүн бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар нэрлэн бичиж, гишүүнчлэл тус бүрийг нотлох баримтыг хавсаргана. -Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана. -Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүргийн нэр, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичнэ.</p>

ДӨРӨВ.ХУУЛЬ ЗҮЙН ӨНДӨР МЭРГЭШИЛ

<p>4.1</p>	<p>Хууль зүйн өндөр мэргэшил Хүсэлт гаргагчийг хууль зүйн өндөр мэргэшилтэй /хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай, мэргэжлийн өндөр ёс зүйтэй/ гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлох бөгөөд үйл ажиллагаа тус бүрийг явуулсныг нотлох баримтыг хавсаргана. Ийм үйл ажиллагаа тус бүрийн талаар дараах мэдээллийг заавал бичнэ: -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/; -тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан гурваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/; -хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.</p>
<p>4.2</p>	<p>Байгаа бол хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл</p>

	<p>-Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-Сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.</p> <p>-Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.</p> <p>Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх цахим холбоосыг тусгана.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
<p>4.3</p>	<p>Байгаа бол Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл (гэрчилгээ) Хуульчийн мэргэжлийн, эсхүл өмгөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зэрэг хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагааны зөвшөөрөлтэй юу, эсхүл ийм зөвшөөрөлтэй байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг зөвшөөрлийг ямар хугацаанд эзэмшиж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
<p>4.4</p>	<p>Байгаа бол магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэг цолны талаарх мэдээлэл Суралцаж төгссөн их, дээд сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, эрдмийн зэрэг, цол авсан огноог бичнэ.</p>
<p>4.5</p>	<p>Сахилгын шийтгэл Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж, эсхүл огцорч байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>

Хавсралт:

Нэр дэвших тухай хүсэлтэд журмын 5.1.2-т заасан дараах баримт бичгийг хавсаргана:

-төрийн албан хаагчийн анкет;
-иргэний үнэмлэхийн хуулбар;
-нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;

-эрх зүйн бакалаврын, эсхүл түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар;

-хууль зүйн өндөр мэргэшилтэй гэдгийг нотлон харуулсан үйл ажиллагааны талаарх баримт;

-эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласныг нотлох баримт;
-энэхүү загварт заасан баримт бичиг;
-холбогдох бусад баримт.

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр:.....

Өөрийн нэр:

Гарын үсэг:

Он, сар, өдөр:

---oOo---

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн
байнгын хорооны 2026 оны 04 дугаар
сарын 29 -ны өдрийн 04 дугаар
тогтоолын 4 дүгээр хавсралт

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНД ГАРГАХ БАТАЛГАА

Шүүхийн ерөнхий зөвлөлийн, эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг хараат бусаар сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн гишүүн.....

/эцэг, эсхүл эхийн нэр, өөрийн нэр/ миний бие Шүүхийн ерөнхий зөвлөлийн, эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд тавих шаардлагыг хамгийн сайн хангасан иргэнийг сонгон шалгаруулахын төлөө өөрийн мэдлэг, чадвар, туршлагаа дайчлан, ёс зүйн өндөр шаардлагыг ханган чармайн ажиллахаа Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд үүгээр баталж байна.

Ажлын хэсгийн гишүүн би Монгол Улсын Шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам /цаашид "журам" гэх/-д захирагдаж ажиллана.

Холбогдох хууль тогтоомж, журам, баримт бичгийг сайтар уншиж судлах болно гэдгээ үүгээр мэдэгдэж байна. Мөн журмын 1.3-т заасан дараах зарчмыг чанд баримтална:

1. хууль дээдлэх;
2. шударга байх;
3. хараат бус байх;
4. бодитой хандах;
5. нээлттэй, ил тод байх;
6. ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.

Ажлын хэсгийн гишүүн би журмын 7.5-д заасан бүрэн эрх, 7.6-д заасан үүрэгтэй танилцсан бөгөөд бүрэн эрх, үүргээ бүрэн ухамсарлаж байна.

Ажлын хэсгийн гишүүний хувьд дээр дурдсан зарчмыг чандлан баримталж, бүрэн эрхээ зохих ёсоор хэрэгжүүлж, үүргээ сахин биелүүлнэ, зөрчвөл хуулийн хариуцлага хүлээнэ гэдгийг хүлээн зөвшөөрч, журмын 7.8-д заасны дагуу энэхүү баталгааг гаргаж байна.

Ажлын хэсгийн гишүүн:

Эцэг/эхийн нэр:.....

Өөрийн нэр:

Гарын үсэг:

Он, сар, өдөр:.....

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн
байнгын хорооны 2026 оны 04 дугаар
сарын 29 -ны өдрийн 04 дугаар
тогтоолын 5 дугаар хавсралт

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН МЭДЭГДЭЛ

Нэг.Шүүхийн ерөнхий зөвлөлийн, эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч
бус гишүүнийг хараат бусаар сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий ажлын
хэсгийн гишүүн

Эцэг/эхийн нэр:	Нэр:	Регистрийн дугаар:
Ажиллаж буй байгууллага:.....	Албан тушаал:.....	
Мэдэгдэл хүлээн авсан: Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо		
Мэдэгдэл гаргаж буй үндэслэл:		

Хоёр.Мэдэгдэл

Шүүхийн ерөнхий зөвлөлийн, эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус
гишүүнийг хараат бусаар сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүн
би доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд өөрийн хувийн ашиг сонирхол нийтийн
ашиг сонирхолтой зөрчилдөх буюу албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд
харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдал бий болсон гэж үзэж Нийтийн албанд
нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан
сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу мэдэгдэж,
тухайн чиг үүргийг гүйцэтгэхээс татгалзаж байна.

Мэдэгдлийг тодорхой бичих:

Гурав.Баталгаажуулалт:

_____ би Шүүхийн ерөнхий зөвлөлийн, эсхүл Шүүхийн
сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн
гишүүний үүргээ чанд ухамсарлан энэхүү мэдэгдлийг үнэн зөв гаргасан болохоо
үүгээр илэрхийлж баталгаажуулж байна.

.....
(Албан тушаал)

.....
(Гарын үсэг)

(.....)
(Гарын үсгийн тайлал)

.....
(огноо)

Дөрөв.Шийдвэрлэсэн байдал

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны шийдвэрийн дагуу Байнгын хорооны дарга /нэр/ _____ би Шүүхийн ерөнхий зөвлөлийн, эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг хараат бусаар сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүн /нэр/ _____ -ийн/ын/ гаргасан мэдэгдлийг хэлэлцэн, үндэслэлтэй гэж үзэж, тухайн чиг үүргийг гүйцэтгэхээс татгалзсаныг хүлээн зөвшөөрсөн болно.

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны даргын баталгаажуулалт:

.....
(Гарын үсэг)

/...../
(Гарын үсгийн тайлал)

.....
(огноо)

---oOo---

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн
байнгын хорооны 2026 оны 04 дугаар
сарын 29 -ны өдрийн 04 дугаар
тогтоолын 6 дугаар хавсралт

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ТАЙЛБАР

Нэг.Шүүхийн ерөнхий зөвлөлийн, эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг хараат бусаар сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүн

Эцэг/эхийн нэр:	Нэр:	Регистрийн дугаар:
Ажиллаж буй байгууллага:.....	Албан тушаал:.....	
Тайлбар хүлээн авсан: Шүүхийн ерөнхий зөвлөлийн, эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг хараат бусаар сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч		
Тайлбар гаргаж буй үндэслэл:		

Хоёр.Тайлбар

Шүүхийн ерөнхий зөвлөлийн, эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг хараат бусаар сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүн би доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд “ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал” буюу өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүнтэй холбоотой зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц нөхцөл байдал бий болсон гэж үзэж Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт заасны дагуу тайлбарлаж, холбогдох нэр дэвшигч тохирлын журмаар хуваарилагдсан тохиолдолд илтгэгч гишүүний чиг үүргийг гүйцэтгэхээс татгалзаж байна.

Тайлбарыг тодорхой бичих:

.....
.....
.....

Гурав.Баталгаажуулалт:

_____ би Шүүхийн ерөнхий зөвлөлийн, эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүний үүргээ чанд ухамсарлан энэхүү тайлбарыг үнэн зөв гаргасан болохоо үүгээр илэрхийлж баталгаажуулж байна.

..... (Албан тушаал) (Гарын үсэг) (.....) (Гарын үсгийн тайлал) (огноо)

Дөрөв.Шийдвэрлэлтийн тэмдэглэл

Шүүхийн ерөнхий зөвлөлийн, эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн ахлагч /нэр/ _____ би Шүүхийн ерөнхий зөвлөлийн, эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг хараат бусаар сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүн /нэр/ _____ -ийн/ын/ гаргасан мэдэгдлийг үндэслэлтэй гэж үзэж, холбогдох нэр дэвшигч тохирлын журмаар хуваарилагдсан тохиолдолд илтгэгч гишүүний чиг үүргийг гүйцэтгэхээс татгалзсаныг хүлээн зөвшөөрч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын 10.1.5-д заасны дагуу тухайн гишүүнийг холбогдох нэр дэвшигчийг хариуцан ажиллахаар хуваарилагдахгүй байх арга хэмжээг авсан болно.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн, эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн ахлагчийн баталгаажуулалт:

..... (Гарын үсэг) /...../ (Гарын үсгийн тайлал) (огноо)

---oOo---

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн
байнгын хорооны 2026 оны 04 дугаар
сарын 29 -ны өдрийн 0.4 дугаар
тогтоолын 7 дугаар хавсралт

**ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮГЧ БУС ГИШҮҮНД
НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ ИЛТГЭГЧ ГИШҮҮНИЙ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

/Зөвхөн Ажлын хэсгийн хэрэгцээнд хэрэглэх бөгөөд Ажлын хэсгийн гишүүнээс
бусад этгээдэд тараах, задруулахыг хориглоно/

Товч удирдамж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам /цаашид “журам” гэх/-ын 10.10-д заасны дагуу Ажлын хэсгийн илтгэгч гишүүн нь мэдээлэл бүрдүүлсний үндсэн дээр өөрт хуваарилагдсан нэр дэвшигчийн талаар дэлгэрэнгүй тайланг энэхүү загварт нийцүүлэн өөрөө бичих үүрэгтэй. Нэр дэвшигчийн талаарх дэлгэрэнгүй тайланг журмын 11.6-д заасан хугацаанд Ажлын хэсгийн бусад гишүүдэд урьдчилан явуулах, журмын 12.1-д заасан хуралдаан дээр Ажлын хэсгийн гишүүн бүрд хувилж цаасаар тараана.

1	Эцэг/эхийн нэр: Ургийн овог: Нэр: Хүйс: Төрсөн он: Төрсөн газар: Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг:
Нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, бүрдүүлэх ажиллагаа	
2	Хүсэлт, баримт бичиг Журмын 10.4.1-д заасан тохирох хүсэлт, баримт бичиг, журмын 10.4.8-д заасны дагуу гаргуулан авсан нэмэлт мэдээлэл, баримт бичиг тус бүрийг судлах, үнэн зөвийг нягталж үндэслэл бүхий дүгнэлт бичнэ. Нэг дугаартай илтгэгч гишүүн: Хоёр дугаартай илтгэгч гишүүн:
3	Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл Журмын 10.4.2, 10.4.6-д заасны дагуу нэр дэвшигчийн олон нийтэд өгсөн мэдээлэл /лекц, илтгэл, нээлтийн үг, ярилцлага, нийтлэл зэрэг/ болон хэвлүүлсэн бүтээл /ном, өгүүлэл, тайлан зэрэг/-ийн товч агуулгыг бичиж, нэр дэвшигчийн бичлэгийн хэв маяг, ойлгомжтой байдал, хууль зүйн дүн шинжилгээ хийх чадвар зэргийг үнэлж нэгтгэн дүгнэж бичнэ. Нэр дэвшигчээс өгсөн, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг бусад эх сурвалжаас цуглуулсан хэвлэмэл материалын хуулбарыг хавсаргана. Нэг дугаартай илтгэгч гишүүн:

	<p>Нэг дугаартай илтгэгч гишүүн:</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>Хоёр дугаартай илтгэгч гишүүн:</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
<p>8</p>	<p>Нэр дэвшигчийн талаарх ярилцлагын товчлол Журмын 10.4.7-д заасны дагуу нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадвар /дүн шинжилгээ хийх, үндэслэл гаргах, шийдвэр гаргах зэрэг/, ажлын туршлага, мэргэжлийн ёс зүй, зан төлөвийн талаар хүмүүстэй хийсэн ярилцлагын товч агуулгыг нэгтгэн үндэслэлтэйгээр дүгнэж бичнэ. Үүнд ярилцагчаас нэр дэвшигчийн талаар өгсөн эерэг, сөрөг мэдээллийг багтаана. Нэр дэвшигч журмын 2.1-д заасан шаардлага тус бүрийг хангасан эсэх талаар ярилцагчаас асууж хөтөлсөн тэмдэглэлийн гол агуулгыг бичнэ. Хэрэв сөрөг мэдээлэл өгсөн бол тухайн мэдээллийг мэдэх бусад хүн, эх сурвалжийг нэрлэхийг ярилцагчаас хүснэ. Үүний мөрөөр сөрөг мэдээлэл дээр хяналтын ярилцлага, судалгааг нэмж хийнэ.</p> <p>Нэг дугаартай илтгэгч гишүүн:</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>Хоёр дугаартай илтгэгч гишүүн:</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
<p>9</p>	<p>Нэр дэвшигчтэй хийсэн ярилцлага, Ажлын хэсгийн хэлэлцүүлгийн товчлол Журмын 10.4.8-д заасны дагуу ярилцлагуудын явцад гарсан сөрөг мэдээллийн талаар нэр дэвшигчтэй ганцаарчлан ярилцаж тэмдэглэл хөтөлнө. Нэр дэвшигчтэй илтгэгч гишүүний ганцаарчлан хийсэн ярилцлагын гол агуулгыг нэгтгэн үндэслэлтэйгээр дүгнэн бичнэ. Мөн болон Ажлын хэсгийн хэлэлцүүлгийн үйл явцын талаар бичнэ. Ярилцлага, хэлэлцүүлгийн явцад хөндөгдсөн гол асуудлууд, илтгэгч гишүүний сэтгэгдэл, бусад хүнтэй хийсэн ярилцлагуудын үед хүлээн авсан сөрөг мэдээлэлд нэр дэвшигчийн өгсөн хариу тайлбар зэрэг мэдээллийг бичнэ.</p> <p>Нэг дугаартай илтгэгч гишүүн:</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>Хоёр дугаартай илтгэгч гишүүн:</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
<p>10</p>	<p>Бусад хэлбэрээр цуглуулсан мэдээлэл Журмын 10.4.9-д заасны дагуу нэр дэвшигчийн талаар үнэлгээ өгөхөд зайлшгүй шаардлагатай мэдээллийг бусад хэлбэрээр цуглуулсан бол энэ талаар танилцуулж, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</p> <p>Нэг дугаартай илтгэгч гишүүн:</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>

	Хоёр дугаартай илтгэгч гишүүн:
Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд тавих шаардлагыг хангасан эсэх үнэлгээ	
11	Хууль зүйн өндөр мэргэшилтэй: хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай эсэх Нэр дэвшигч нь Шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.3 дахь хэсэгт заасан шаардлагын хүрээнд “хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай” эсэхийг цуглуулсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан үнэлж үндэслэлтэйгээр дүгнэж тодорхой, ойлгомжтой бичнэ. Нэг дугаартай илтгэгч гишүүн: Хоёр дугаартай илтгэгч гишүүн:
12	Хууль зүйн өндөр мэргэшилтэй: мэргэжлийн ёс зүйн өндөр шаардлага хангасан эсэх Нэр дэвшигч нь Шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.3 дахь хэсэгт заасан шаардлагын хүрээнд “бусдын нөлөөнд автахгүй, хараат бусаар ажиллах, зарчимч, шударга зан төлөвтэй, мэргэжлийн ёс зүйн өндөр шаардлагыг хангасан” эсэхийг цуглуулсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан үнэлж, үндэслэлтэйгээр дүгнэж тодорхой, ойлгомжтой бичнэ. Нэг дугаартай илтгэгч гишүүн: Хоёр дугаартай илтгэгч гишүүн:
13	Эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан эсэх Шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.3 дахь хэсэгт заасны дагуу эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан эсэхийг цуглуулсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан үнэлж, үндэслэлтэйгээр дүгнэж тодорхой, ойлгомжтой бичнэ. Нэг дугаартай илтгэгч гишүүн: Хоёр дугаартай илтгэгч гишүүн:
14	Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн эсэх Шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.3 дахь хэсэгт заасны дагуу “төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй” байх шаардлагыг хангаж

	<p>байгаа эсэхийг цуглуулсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан үнэлж, үндэслэлтэйгээр дүгнэж тодорхой, ойлгомжтой бичнэ.</p> <p>Нэг дугаартай илтгэгч гишүүн:</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>Хоёр дугаартай илтгэгч гишүүн:</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
